



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А/868

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн 4/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Некст дэвшил" ХХК буюу "Олон ястны телевиз" Юнивишн ХХК-тай телевизийн нэвтрүүлгийг дахин дамжуулж иргэд хэрэглэгчдэд хүргэхээр байгуулсан гэрээг үндэслэн "Телевизийн нэвтрүүлэг дамжуулсаны түрээсийн төлбөр"-т дэмжлэг үзүүлсүгэй.

2. "Телевизийн нэвтрүүлэг дамжуулсаны түрээсийн төлбөр"-т дэмжлэг болгон олгох 3.0 төгрөг /гурван сая/-ийг Хөшөөт хөгжил сангийн "2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээ"-ний 5.8 дахь заалтад тусгасан Юнивишн, Ddish дахин дамжуулах сүлжээнд орон нутгийн телевизийг холбох зардлаас гаргасугай.

3. Дээрх арга хэмжээнд зарцуулах санхүүжилтийг холбогдох баримт, бичгийн дагуу тооцон шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.


4. Тухайн телевизийн нэвтрүүлгийн дахин дамжуулалт, үйлчилгээний чанар, хүртээмжид хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээллийн ажилтан /Х.Алтантуяа/-д үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

D/Zah-A/868-Bo

Аймгийн Засаг даргын 2021 оны
12 дугаар сарын 27-ны өдрийн
А/868 дугаар захирамжийн хавсралт



ТЕЛЕВИЗИЙН НЭВТРҮҮЛЭГ ДАМЖУУЛСАНЫ
ТҮРЭЭСИЙН ЗАРДАЛ

№	Байгууллагын нэр	Дэмжлэг үзүүлэх эх үүсвэр	Санхүүжилтийн хэмжээ
1	“Некст дэвшил” ХХК	“2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээ”-ний зардал	3 000 000

-оОо-